

## МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 18/3

Улаанбаатар хот

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан удирдав. Хуралдаанаар Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 баримтлах үндсэн чиглэлийн төсөл, бодлогын хүү болон макро зохистой бодлогын арга хэмжээнүүдийн талаар хэлэлцлээ.

МБХ-ны хуралдааны эхний хэсэгт үндсэн чиглэлийг боловсруулах ажлын хэсгээс Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 баримтлах үндсэн чиглэлийн төслийг танилцуулав.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөлд жил бүр багтдаг заалтуудаас гадна дараах онцлох бодлогын арга хэмжээнүүдийг шинээр тусгасан болохыг танилцууллаа. Үүнд:

1. Гадаад валютын улсын нөөцийн зохистой түвшин хуримтлуулах нь эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлж, гадаад сөрөг цочролын эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг бууруулна. Мөн эдийн засгийн хямрал, хүндрэлийг хохирол багатай даван туулахад ашиглагдах бодлогын орон зайг нэмэгдүүлэх ач холбогдолтой учир “Эдийн засгийн дархлааг дэмжих, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг оруулсан болохыг онцоллоо.
2. Гадаад сөрөг цочролын нөлөөллөөс үүдэн санхүүгийн секторын эмзэг байдал нэмэгдэх, эдийн засгийн хямрал даамжрах, мөчлөгийн далайц нэмэгдэх эрсдэлтэй тул макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж, эдгээр эрсдэлээс зайлсхийх боломж бүрдэнэ гэж үзсэн. Энэ хүрээнд “Банк, санхүүгийн салбарын тогтвортой байдал, эрсдэл даах чадварыг хадгалах зорилгоор банкуудын өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг оруулсан.
3. ОУВС-тай хамтран хэрэгжүүлж байгаа Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт тусгасан шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх, энэ хүрээнд активын чанарын иж бүрэн үнэлгээ, банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээтэй байдал болон төлбөрийн чадварыг сайжруулах арга хэмжээг авах зорилгоор “Банк, санхүүгийн салбарын тогтвортой байдал, эрсдэл даах чадварыг хадгалах зорилгоор банкуудын өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг тусгасан байна.
4. “Олон улсад мөрдөж буй тогтвортой санхүүжилтийн нийтлэг зарчим, шилдэг туршлагыг нэвтрүүлнэ” гэсэн заалтыг мөн шинээр боловсруулсан байна. Энэхүү заалт нь байгаль орчин, олон нийтэд ээлтэй бөгөөд хүртээмжтэй эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох зорилгоор тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийг Монголын банк санхүүгийн системд нэвтрүүлэх ажлыг дэмжих зорилготой.
5. Санхүүгийн технологийг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төлбөр тооцооны үйлчилгээний зардлыг бууруулахад шаардлагатай дүрэм, журам, зааврыг

шинэчлэн боловсруулж мөрдүүлэх; Төлбөрийн картын чипийг шинэчилж байгаатай холбоотойгоор төлбөрийн шинэчлэгдсэн чип дээр суурилсан технологийн шинэ финтекийн үйлчилгээнүүдийг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх; Санхүүгийн системд нэгдсэн тоон гарын үсгийг нэвтрүүлэх ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөөд байгаа бөгөөд энэ нь банк болон санхүүгийн хэрэглэгчийг таних зардал буурч, улмаар санхүүгийн үйлчилгээг авахад илүү хялбар болох ач холбогдолтой тул “Банк санхүүгийн салбарт технологийн дэвшил, шинэ ололтыг нэвтрүүлэх замаар санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, өртөг зардлыг бууруулах, мэдээллийн аюулгүй, найдвартай байдлыг хангахад чиглэсэн дэд бүтцийг хөгжүүлж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг бий болгоно” гэсэн заалтыг оруулсан болохыг тус тус танилцууллаа.

Ийнхүү МБХ-ны гишүүд Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг Улсын Их Хурлын тогтоолын төслийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх саналыг 100 хувь дэмжлээ.

МБХ-ны хуралдааны дараагийн хэсэгт эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв, инфляци, эдийн засгийн өсөлт, гадаад эдийн засгийн орчин, хөрөнгө санхүүгийн зах зээл, эдгээрт гарч буй өөрчлөлтүүдийн талаар Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцуулав.

Инфляци мөнгөний бодлогын үндсэн зорилттой нийцтэй, цаашид зорилтот түвшний орчимд тогтворжих төлөвтэй байгааг МБГ-аас онцлов. Тайлант онд малын зүй бус хорогдол өндөр байсан, зуншлага оройтсоноос үүдэн махны үнэ өмнөх оноос өсч, хүнсний инфляцийг нэмэгдүүлэх нөлөө үзүүлсэн. Цаашид эрэлтийн шинжтэй инфляци алгуур нэмэгдэх боловч нийлүүлэлтийн болон нэг удаагийн шинжтэй хүчин зүйлсийн нөлөө (хэрэглээний сагсны өөрчлөлт, суудлын автомашины татвар, хатуу түлшний үнийн огцом өсөлт) саарч хүнсний бус инфляци 2018 онд буурахаар байна. Харин 2019 оноос уул уурхайн бус салбарын идэвхжил болон цалин нэмэгдэх нөлөөгөөр жилийн инфляци өсөх хүлээлттэй байгаа хэдий ч зорилтот түвшний орчимд тогтворжих хүлээлттэй байгааг танилцууллаа.

Эдийн засгийн идэвхжил цаашид нэмэгдэхээр байгааг тодотгов. 2018 онд зэсийн баяжмал дахь алтны агууламж эргэн сэргэж, нүүрсний зах зээл тогтвортой байгаа нь уул уурхайн салбарын өсөлтийг нэмэгдүүлэх бол хөрөнгийн дотогшлох урсгал сайжрах, бизнес эрхлэгчдийн итгэл сэргэх зэрэг хүчин зүйлсийн голлох нөлөөгөөр уул уурхайн бус салбарын өсөлт харьцангуй тогтвортой хадгалагдахаар байна. Харин 2019 онд түүхий эдийн үнэ буурахаар хүлээгдэж байгаа нь уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хумих нөлөө үзүүлэх бол Активын чанарын үнэлгээний хүрээнд хийгдэх ажлууд жигдэрснээр бизнесийн зориулалттай зээл болон банкны ашигт ажиллагаа нэмэгдэж, хөрөнгө оруулалтын хэмжээ хэвийн түвшиндээ хүрч улмаар уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл нэмэгдэх хүлээлттэй байна.

МБГ-ын танилцуулснаар гадаад эдийн засгийн төлөв хүлээлтээс муудсан байна. Үүнд Хятадын эдийн засгийн өсөлт 2018 онд хүлээлтээс бага буюу 6.5 хувь, Евро бүсийн эдийн засаг 1.8 хувьд хүрэхээр байгаа нь голчлон нөлөөлжээ. Монгол улсын экспортын гол нэрийн

бараа болох зэс, алтны дэлхийн зах зээл дээрх үнэ хүлээлтээс бага байсан нь экспортын үнэ буурахад голчлон нөлөөлсөн байна.

Санхүүгийн дансны цэвэр орох урсгал нэмэгдсэн ч урсгал дансны алдагдал илүү ихээр тэлснээр нийт төлбөрийн тэнцлийн ашиг 2018 онд буурахаар байгааг дурдлаа. Урсгал дансны хувьд уул уурхайн салбарын идэвхжил, нефтийн үнийн өсөлт, хэрэглээний зээлийн өсөлт болон юанийн ханш суларсан зэргээс шалтгаалан импорт хурдтай тэлж, уг дансны алдагдлыг өсгөхөөр байна. Санхүүгийн тэнцлийн хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО), гадаад зээл нэмэгдэхээс шалтгаалан тус дансны ашиг өсөхөөр байгааг дурдав.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарч байгаа ч бүтцийн хувьд өөрчлөгдөж байна. Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн донор байгууллагуудын санхүүжилтээр төсвийн алдагдлыг санхүүжүүлж байгаатай холбоотойгоор гадаад валютын цэвэр нөөц өсч, Засгийн газрын үнэт цаас буурсан байна.

Нийт зээлийн өсөлт аажмаар нэмэгдэж 2018 оны 8 дугаар сард 17.6 хувьд хүрсэн. Үүний 11 нэгж хувийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. Хэрэглээний зээл эрчимтэй өсч байгаа ч бизнесийн зээлийн өсөлт сүүлийн 2 улиралд нэмэгдэх хандлагатай байна. Тодруулбал, бизнесийн зээлийн дийлэнх хэсгийг худалдаа, боловсруулах, уул уурхайн салбарт олгосон болохыг онцоллоо.

Мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр бодлогын хүүг 2017 оноос үе шаттайгаар бууруулж, 10 хувьд хүргэсэн. Бодлогын хүүний шийдвэртэй холбоотойгоор банкуудын зээлийн болон хадгаламжийн хүү буурч байна. Зээлийн хүү буурах нь аж ахуйн нэгжүүдийн зээлийн эрэлт болон банкны системийн бизнесийн зээл олголтыг нэмэгдүүлж, улмаар бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих ач холбогдолтой болохыг дурдав.

Үргэлжлүүлээд төсөөллийн тодорхой бус байдлыг хэлэлцэв. Дотоод орчны хувьд нийлүүлэлт талаас цаг агаарын нөхцөл байдал, шатахууны үнийн зохицуулалт, эрэлт талаас цалин нэмэгдэх, томоохон төслүүдийн хөрөнгө оруулалтууд нэмэгдэх зэрэг тодорхой бус байдлуудыг онцолсон бол гадаад эдийн засгийн хувьд геополитикийн асуудлууд болон АНУ, БНХАУ хоорондын худалдааны зөрчилдөөн, түүний экспортын барааны үнэд үзүүлэх нөлөө зэрэг нь тодорхой бус байдлын гол эх сурвалж болж байгааг онцоллоо.

Суурь төсөөллөөр 2018 онд инфляцийн түвшин зорилтот түвшнээс доогуур буюу 7.1 хувь, эдийн засгийн өсөлт 6.2 хувь байхаар байна.

Бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах мөнгөний бодлогын газрын саналыг шүүмжлэх, дэмжих хэлбэрээр хэлэлцүүлэг өрнөв.

Мөнгөний бодлогын хорооны гишүүдийн хувьд эдийн засгийн идэвхжил харьцангуй өндөр байгаа өнөө үед бизнесийн идэвхжлийг бууруулахгүй байхын тулд бодлогын хүүг хэвээр нь хадгалах нь зүйтэй гэж үзсэн. Мөн эдийн засгийн өсөлт нэмэгдэж байгаа хэдий ч зээлийн чанар бүх салбарт сайжирч эхлээгүй байгаа нь эдийн засаг бүрэн идэвхжиж эхлээгүй байгааг дохиолж байна гэж үзсэн.

Зарим гишүүд бодлогын хүүг хэвээр хадгалах саналыг дэмжээд гадаад эдийн засгийн орчноос үүдэн бодлогын хүүг өсгөх дарамт үүсээд байгааг олон нийтэд ил тод мэдээлэх нь зүйтэй болохыг сануулсан.

Мөнгөний бодлогын хорооны гишүүд бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах саналыг 100% дэмжлээ.

Хуралдааны дараагийн хэсэгт макро зохистой бодлогын хүрээнд “Ханшийн эрсдэлтэй иргэд, аж ахуйн нэгжид олгосон гадаад валютын бусад зээл”-ийн эрсдэлийн жинг 120%-иас 150% болгож нэмэгдүүлэх шаардлагын талаар хэлэлцлээ.

Сүүлийн саруудад шинээр олгосон зээлийн 20 гаруй хувийг тогтмол гадаад валютаар олгож, нийт зээлийн үлдэгдлийн долларжилт алгуур нэмэгдэж байгааг танилцууллаа. 2018 оны 7 дугаар сарын байдлаар шинээр олгосон гадаад валютын зээлийн дийлэнх хэсгийг худалдаа, боловсруулах, уул уурхайн салбаруудад олгосон бөгөөд гадаад валютын нийт зээлийн 60 орчим хувийг ханшийн эрсдэлтэй иргэд, аж ахуй нэгжүүдэд олгосон байна. Уул уурхайн салбарын орлого нь гадаад валютаар бүрддэг тул валютын зээлийн ханшийн эрсдэл харьцангуй хязгаарлагдмал. Харин худалдаа, боловсруулах салбарууд ихэвчлэн дотоод худалдан авалт, түүнд чиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээ явуулдаг тул орлогын дийлэнх хэсэг нь төгрөгөөр бүрддэг. Эдгээр салбаруудын хувьд валютын зээлийн хэмжээ өндөр байгаа нь ханшийн эрсдэлийн гол сурвалж болж байна.

Төгрөгийн нэрлэсэн ханш харьцангуй тогтвортой байсантай уялдан аж ахуй нэгжүүдийн гадаад валютаар зээл авах хандлага нэмэгдэж байгаа бөгөөд зээлийн долларжилт цаашид хурдацтай нэмэгдвэл санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Монгол Улсын санхүүгийн системд ханшийн эрсдэлийг удирдах үүсмэл хэрэгслүүд хөгжөөгүй үед гадаад сөрөг цочрооны нөлөөгөөр төгрөгийн ханш сулрах дарамт үүсвэл гадаад валютын орлогогүй, ханшийн эрсдэлээ удирдах чадамжгүй зээлдэгчдийн ханшийн эрсдэл нь банкны салбарт зээлийн эрсдэл болж хувирах эрсдэлтэй байна.

Мөн бодлогын хүүний өөрчлөлт, макро эдийн засгийн орчны нөлөөгөөр төгрөг болон валютын зээлийн хүү аль аль нь сүүлийн саруудад буурч байгаа боловч төгрөг болон валютын зээлийн хүүний зөрүү сүүлийн 2 жилийн хугацаанд өсөх хандлагатай байгааг танилцуулав. Цаашид банкууд валютын хадгаламж, харилцахыг валютын зээл болгон гаргах орон зай өндөр байгааг онцоллоо.

Монголбанкны “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д заасан “Ханшийн эрсдэлтэй иргэд, аж ахуйн нэгжид олгосон гадаад валютын бусад зээл”-ийн эрсдэлийн жинг 120%-иас 150% болгож нэмэгдүүлэн, 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдүүлэх саналыг хэлэлцэж, шүүмжлэх, дэмжих хэлбэрээр хэлэлцүүлэг өрнөв.

Мөнгөний бодлогын хорооны гишүүдийн хувьд арилжааны банкны зээлийн долларжилтыг бууруулах энэхүү бодлогын арга хэмжээг авах нь зүйтэй гэж үзсэн. Иймд санхүүгийн системийн тогтвортой байдлыг хамгаалах үүднээс ханшийн эрсдэлтэй иргэд, ААН-д олгосон валютын зээлийн эрсдэлийн жинг 150% болгон нэмэгдүүлж, 2019 оны 1 сарын 1-нээс мөрдүүлэх саналыг 100% дэмжлээ.

Хуралдааны сүүлийн хэсэгт макро зохистой бодлогын хүрээнд иргэдийн зээлийн хугацааг хязгаарлах талаар хэлэлцлээ.

Цаашид өр, орлогын харьцаа нь өндөр, зээл нэмж авах сонирхолтой иргэд өр, орлогын харьцаагаа алдагдуулахгүй боловч зээлийн хугацааг сунгах замаар зээл нэмж авч, өрөө нэмэгдүүлэх эрсдэлтэй байгааг Мөнгөний бодлогын газар онцлов. 2018 оны 5 дугаар сарын байдлаар иргэдийн хэрэглээний зээлийн дундаж хугацаа 27 сар байгаа бол өр, орлогын харьцаа нь 70%-иас дээш иргэдийн хэрэглээний зээлийн дундаж хугацаа нь 24 сар байна. Мөн, нийт хэрэглээний зээлийн 70% нь 36 сараас богино хугацаатай байгаа боловч эдгээр зээлийн дундаж өр, орлогын харьцаа нь 71.4%-д хүрсэн байна.

Өр, орлогын харьцаа өндөр зээлдэгчид цаашид өр, орлогын харьцаагаа алдагдуулахгүй боловч зээлийн хугацааг уртасгах замаар хэрэглээний зээлийг нэмэгдүүлбэл хэрэглээний зээлийн хурдацтай өсөлтийг хязгаарлах, улмаар санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах зорилготой иргэдийн өр, орлогын харьцааг 70%-иар тогтоосон макро зохистой бодлогын арга хэмжээ үр нөлөөгүй болох эрсдэлтэй. Иймд уг бодлогын арга хэмжээний үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор МБГ-ын зүгээс банкнаас шинээр олгох, нөхцөлийг нь өөрчлөх иргэдийн хэрэглээний зээлийн хугацааг 24 эсвэл 30 сараас хэтрүүлэхгүй байхаар тогтоож, 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдүүлэх саналыг гишүүдэд танилцуулав.

Мөнгөний бодлогын хорооны гишүүдийн хувьд иргэдийн өр, орлогын харьцааг 70%-иар тогтоосон макро зохистой бодлогын арга хэмжээ үр нөлөөгүй болж, иргэдийн өрийн дарамт нэмэгдэх эрсдэлтэй тул иргэдийн зээлийн хугацааг хязгаарлаж өгөх нь зүйтэй гэж үзсэн.

Ийнхүү МБХ-ны гишүүдийн хувьд зээл хурдацтай өсч, өрхийн өрийн дарамтыг нэмэгдүүлж, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байгаа гэж үзсэн тул макро зохистой бодлогын хүрээнд ипотекийн бус иргэдийн хэрэглээний зээлийн хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байхаар тогтоож, 2019 оны 1 сарын 1-нээс мөрдүүлэх саналыг 100% дэмжлээ.

### **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Монголбанкны МБХ-ны 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн хурлаар бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах, макро зохистой бодлогын хүрээнд банкнаас иргэдэд шинээр олгох, нөхцөлийг нь өөрчлөх ипотекийн бус хэрэглээний зээлийн хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байхаар тогтоох, иргэд болон аж ахуй нэгжид олгосон ханшийн эрсдэлтэй валютын зээлийн эрсдэлийн жинг 150% болгон нэмэгдүүлэх шийдвэрүүдийг гаргалаа.

Бодлогын хүүний шийдвэрийг 2018 оны 9 дүгээр сарын 21-ны өдрөөс, ипотекийн бус иргэдийн хэрэглээний зээлийн хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байх, валютын зээлийн эрсдэлийн жин нэмэгдүүлэх шийдвэрийг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдүүлэхээр тогтов.